

Хөвсгөл нуурт живсэн машинуудын зарим мэдээлэл

Хөвсгөл нуур бол Монгол орны цэвэр усны хамгийн гол нөөц бөгөөд Монгол орны цэвэр усны нөөцийн 70 орчим хувь, дэлхийн цэвэр усны нөөцийн 1 хувийг бүрдүүлдэг билээ. Энэ нуураас зөвхөн Эгийн гол эх авдаг ба Эгийн гол нь Сэлэнгэ мөрөнтэй нийлэн Байгаль нуурт цутгадаг. Хөвсгөл нуур нь манай орны төдийгүй Төв Азийн хэмжээнд хамгийн гүн, цэнгэг нуур юм. Нийт усны эзлэхүүн 381 км³, энэ нь дэлхийн нийт цэнгэг усны 0.4% болно. Нуур нь 136 км урттай, 20-40 км өргөнтэй, 260 орчим метр гүнтэй, эргийн шугамын урт 414 км юм.

Хөвсгөл нууранд Модон хүй, Хадан хүй, Далайн хүй, Бага хүй гэсэн 4 арал бий. Эдгээрээс хамгийн том нь “Далайн хүй” арал бөгөөд усны мандлаас 126 метр өндөр, 3 километр урт, 2 километр өргөн, 5.8 ам километр талбайтай, битүү ой модоор хучигдсан арал байдаг. “Хадан хүй” арал нь өндөр өндөр хясаатай тул шувууд их цугладаг. “Модон хүй” нь онцгой сайхан байгальтай. Усны тунгалагшилт нь 24.5 метр байдаг. Эргийн хаданд хүрлийн үеийн сүт зурагнууд бий.



Өнөө цагт бид энэхүү цэнгэг уст, үзэсгэлэн төгс Хөвсгөл нуураа аялал жуулчлалын зориулалтаар түлхүү ашиглаж байна. Харин 1990-ээд оноос өмнө хүйтний улирал эхэлж нуур мөсөн бүрхүүлтэй байх үед нуурын мөсөн дээгүүр Хатгал тосгон ба ОХУ-ын хил орчмын суурин газруудын хооронд тээврийн хэрэгслээр бараа материал, шатахуун тээвэрлэж байсан ба зун нь тус бараа бүтээгдэхүүнээ усан онгоцоор тээвэрлэдэг байжээ. Өнөө үед нуурыг бохирдохоос хамгаалах үүднээс мөсөн дээрх тээвэрлэлтийг бүрэн зогсоосон болно. Тухайн үед өвлийн улиралд шатахуун ачсан машинууд мөс цөмлөн живж нуурын усанд орох тохиолдлууд гардаг байсан. Харин нуурын ёроолд унасан тэдгээр машины тоо, байршил одоо болтол тодорхойгүй, таамаг төдий байсаар байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин, техникийг татан гаргах ажлыг олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулахаар тусгасан байдаг. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Хөвсгөл далайн бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээ”-ний тухай 193 дугаар тогтоол, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2021 оны гуравдугаар сарын 9-ний өдрийн А-74 тоот тушаалын хүрээнд 2021 оны 8 сард Хөвсгөл далайд живсэн машин техникийг илрүүлэх, татаж гаргах ажлыг зохион байгуулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, нуурын орчинд байгуулах судалгааны баазын

байршлыг тогтоох зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын сайд Н.Уртнасангаар ахлуулсан Ажлын хэсэг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд ажилласан байдаг. Энэ мэтчилэн Хөвсгөл далайн ёроолоос техник хэрэгслийг гаргах ажлууд хийгдэж байгаа мэт боловч яг хэрэгжүүлэх үе дээрээ хөрөнгө мөнгөний асуудлаас болон төдийлөн ахиц дэвшилгүй байсаар байна.

Хөвсгөл нуурын ёроолд албан бус тоогоор 40-60 орчим тээврийн хэрэгсэл живсэн гэж үздэг. Үүний хэд нь дотроо шатахуунтай, хэд нь өөр төрлийн машин байсныг аман яриагаар л хэлдэг. Харин энэ удаа миний бие уг живсэн машины тоог үнэн бодитой гаргах судалгаанд нэмэр болох үүднээс 1970-1995 оны хугацаанд Авто тээврийн 24-р бааз болон Усан замын газарт удирдах албан тушаал хашиж байсан ахмад настан С.Сандагаас аман судалгаа авч, ажиллаж байх хугацааны хуучны зарим протоколтой танилцан судалгаа хийж, 1995 оноос өмнөх усанд живсэн машины тоог ойролцоогоор гаргасан болно. С.Сандаг нь олон нийтийн хэрэгслээр явж буй 50 гаруй машин живсэн гэдэг тоог үндэслэл муутай тоо байх гэж үзэж байгаагаа илэрхийлсэн. Харин өөрийнх нь мэдэж буйгаар бол *“1979 онд ЗИЛ-130 чиргүүлтэй 11тн үрийн бордоотой машин Долоон уулын шар булан хэмээх газарт, 1982 онд ЗИЛ-130 ТСВ-6 цистерн чиргүүлтэйгээ 9тн шатахуунтай Хачмын үзүүр хэмээх газарт, Ханх сумын хүн эмнэлгийн ГАЗ-69 Долоон уулын ард, Завханы 20-р баазын ЗИЛ-130 машин 5тн бараатай Далийн урд талд Модон хүй арлын тушаа газарт, 1996 онд ЗИЛ-130 ТСВ-6 цистерн, 10тн шатахуунтай Марааны булан хэмээх газарт, 1990 онд 19-р баазын ЗИЛ-130, чиргүүлтэй 10тн давстай машин тус тус живсэн гэж үздэг.”* Харин 1990-ээд оноос хойших нуурт живсэн машины тоог сайн мэдэхгүй байна гэдгээ хэлсэн билээ.

Нуурын ёроолоос живсэн машин техникийн хогийг цэвэрлэхийн тулд багагүй хөрөнгө хүч шаардах нь тодорхой бөгөөд уг живсэн машинууд нуурын яг хаана ёроолд байгааг эрж олох нь ч тийм амар биш байж таарна. Гэсэн хэдий живсэн машины байршлыг мэдэж байгаа тохиолдолд хөрөнгө хүч хэмнэх нь тодорхой. Байршлыг мэдэж буй тохиолдолд хөлөг онгоцоор явж очоод асар урт тороосоор татаад хөлөг дээр гаргачих боломжтой хэмээн зарим эх сурвалжууд мэдээлсэн байдаг. Энэ ажил нь мэдээж гадны мэргэжлийн баг, техник хэрэгслийг ашиглах нь тодорхой юм. Эцэст нь хэлэхэд тухайн үед Ханх, Хатгалын авто тээвэр, усан замын газарт ажиллаж байсан ахмадуудыг амьд сэрүүн үед нь асууж тодруулах, аман судалгааны ажлыг үр дүнтэй сайн хийснээр далайд орсон машинуудын байршил тогтоох их хэмжээний зардлаас сэргийлэх боломжтой. Тиймээс энэхүү бэлтгэсэн мэдээлэл нь энэ чиглэлийн судалгаа хийж буй зарим хүмүүст хэрэг болно гэдэгт итгэж байна.